

Хүүхдийн номын ордон

Мореедел танхим



Данс: 3389 (БКМОН) / 03003389

Шалт: ББК 84.8(5МОН) / Ц.956



Орчин үеийн

ТЭГМЭЛ



## **Агуулга**

МЯТАВЫН СУРАГ

НЭГЭН СЭХЭЭ

ХУСНЫ ШИД

ГАЙХАМШИГТ СОРОНЗОН

НЭГ СУМААР ХОЁР ЧОНО

УТАС ОЛСНООС ХҮЧТЭЙ

МЭХЭЭРИЙН АМТ

ХӨШҮҮРГИЙН ЭРДЭМ

ДАХИАД Л ТОМИЛОЛТ АВАХААС ДАА

1983 оны хэвлэлийн Хэвлэн нийтлэлийн мэдээлэл :

## Ш. ЦЭНД-АЮУШ

### АДТАЙ МЯТАВ

(Тууж)

“БНМАУ. Ардын боловсролын яамны хэвлэл” Улаанбаатар хотноо 1983 онд эрхлэн хэвлүүлсэн Хоёрдох удаагийн хэвлэлээс

“Цагаан бамбарууш” хэвлэлийн газар 2015 онд цахим хэлбэрт хөрвүүлэв.



## МЯТАВЫН СУРАГ

Нэг өдөр сонины эрхлэгч намайг дуудаж

Чамайг томилолтоор хөдөө явуулж, Мятав гэдэг хүний тухай сурвалжлуулахаар боллоо. Тэр хүн саяхан, шатаж байгаа таван давхар байшингийн тагтан дээрээс нэгэн хүүхдийг буулган авч амийг нь аварсан байна гэлээ. Би «буулган авч гэнэ үү? Өөрөө дор нь байж байгаад шат тавьж өгсөн хэрэг үү?» гэж асуулаа. Эрхлэгч:

— Ийм учиртай юм гэнэ. Үүдний өрөөнөөс нь гэнэт хүчтэй гал дүрэлзэн асахад найман настай жаал хүү яах ч аргаа ололгүй тагтан дээрээ зугтан гарчээ. Удалгүй хойноос нь харанхуй хар утаа хуйлран баагьж, юу ч үлдээлгүй хуйхлах гэсэн шиг улаан гал өрвөлзөн эрчилж, үе үе хүүхдийн биед хүрч байжээ.

Гудамжид цугларсан хүмүүс хий дэмий «Хаалга нь дотроосоо түгжээтэй юм. Одоо яана аа. Бусад нь дүүрч, тэр хүүг л авах юмсан, шат байгаад хүрэхгүй нь. Юун ч өндөр юм бэ» гэх зэргээр учир замбараагүй шуугилдаж, юу хийхээ мэдэхгүй самгардан бужигналдсан гэнэ. Гэтэл Мятав тэдэн дээр ирж, байдлыг мэдмэгц манайхаас урт олс аваад ир гэж хүүхэд гүйлгэжээ. Бүх хүмүүсийн найдвар гагцхүү Мятавт хандаж түүний хэлэх, хөдлөхийг л харцгааж байжээ. Хүүхэд олс авчирмагц Мятав үзүүрийг дээш Шидэж, тэвдэж сандарсан хүүд:

— Тайван бай. Олсны үзүүрээр биеэ ороон сайн барь. Тэгээд доошоо үсэр! гэлээ. Хүү ч заасан ёсоор нь үсэрчээ. Харж зогссон хүмүүс цөм дуу алдацгаав. Мятав хүүг үсэрмэгц хүчийг нь дагуулан олсоо хүчтэй эргүүлжээ. Олноос зуурсан хүү гайхан шуугилдаж байсан хүмүүсийн толгой дээгүүр Мятавын гарын аясаар эргэлдэж гарчээ. Тэгснээ Мятав эрчийг нь бууруулан бууруулсаар хүүг дэргэдээ буулгаж авсан гэнэ.

«Хачин юм даа» гэж намайг дуу алдахад эрхлэгч

— Нээрээ тун сонин юм шүү. Би дуулснаа л чамд ярьж өглөө. Сайн сурвалжилбал өөр юм ч олдож магадгүй гэсэн юм. Ингээд би Мятав гуайг эрэн сурвалжлахаар хүлгийн жолоог хөдөө тийш нь заллаа.

\* \* \*

Надтай хуучилж суугаа хүнийг Баяр гэдэг юм. Тэр, хашир хянуур, нягт нямбай, үг дуу цөөнтэй ч үнэн яриатай, өргөн мэдлэг, арвин туршлагатай, нутаг усныхандаа үлгэрч түүхч гэж алдаршсан хүн.

Баяр гуай нутаг орныхоо түүх, уул усны домог, тэндээс төрсөн алдар цуутнуудын тухай олон юм мэднэ. Гиймээс ч би Баяр гуайг Мятавын сонин явдал руу нэвтрэн орох «гүүр», эрлийн эхэн болж чадах хүн гэж найдан, хэрэг болгож зорьж ирсэн юм.

— Та Мятав гэдэг хүнийг таних уу? гэж би шууд яриа өдлөө.

— Адтай Мятав уу? Би сайн танина. Дотор сайтай, ухаан сийрэг, цэцэн цэлмэг хүн юм шүү дээ гэлээ.

Тэгвэл тэр хүнийхээ тухай надад нэг сайн ярьж өгөөч. Тун их хэрэг болоод байна гэвэл.

— Ажил үйлсийг нь ярих юм уу. Авир төрхийг нь хэлэх юм уу гээд инээмсэглэлээ.

— Аль алиныг нь... гэж би дуу алдав.

Баяр гуай:

— Манай нутгийнхан түүнийг адтай Мятав, ачтай Мятав гэдэг юм. Нэг үе манайхан бишгүйдээ л айл аймаг явдаг байлаа. Хатирдаг морь, хэцүү ан, сайхан айрагт дуртай, нутаг усныхандаа нэр төр сайтай, дөлгөөн сайхан зантай, тусархуу, ажилсаг, эртэч, наргиан хөгжөөнтэй, хөдөө нутагт олон тааралдах жирийн л нэг гүдэс шулуун хүн дээ. Овор төрхийг нь яривал, унжуудуу хамар, урт эрүүтэй, сэргэлэн хурц нүдтэй, амьдралын олон он жилийн хугацаанд хал дол үзсэнийг гэрчлэх мэт хэдэн гүн үрчлээ суусан өргөн магнай, тэгш сайхан шүд бүхий, чээж тэвхгэр зузаан, залуудаа сайхан эр явсан болов уу гэмээр янхигардуу чацархаг биетэй, хөнгөн шингэн нэг үгээр хэлбэл, нүдэнд дулаахан сайхан өвгөн байдаг гэдгийг л би сайн мэдэх юм.

Мятав сүүлхэнтэйгээ нэг хэсэг нэгдлийн хонь хариулж байлаа гэсэн. Хөдөлмөрийн баатар болоогүй ч мал маллахын эрдэм ухааныг сайн мэддэг, нэгдлийн урдаа барьдаг хоньчны нэг гэгдэж, сонин хэвлэлд ч гарч байсан байх аа.

— Хүний байдал ерөнхийдөө ийм байж. Ажил хэргээс нь?... гэж намайг шамдуулахад Баяр гуай сахлаа имэрч:

— Ах чинь үнэрхэж байгаа юм биш. Үлгэр домог бол яриад л өгөх сөн. Буух эзэнтэй буцах замтай юмыг тэгж болохгүй ээ. Мятав гэдэг чинь үлгэр домгийн баатар биш, жинхэнэ эгэл жирийн хүн шүү дээ гэж инээмсэглээд

— Чи эхлээд хоршооны манаач Өлзийтэй уулз. Мятав, Өлзий хоёр чинь цуг дайтаж явсан улс. Тэр чамд мундахгүй юм хэлж ч өгнө. Хэнтэй уулзахыг зааж ч чадна гээд тамхиа сорж хэсэг сууснаа горьдсон гуйсан нүдээр өөрийг нь ширтэн суугаа намайг харж өрөвдсөн бололтой.

— Чи ер нь салахгүй шинжийн эр үү дээ. Үзэж дуулсан ганц нэг юмаа ярьж үзэхээс дээ хэмээн бүдэгхэн шивнэж хойно өгүүлэх хоёр явдлыг ярьж өгсөн юм. Ийнхүү эрэл маань бүтэмжтэй эхэллээ.

## НЭГЭН СЭХЭЭ

Олон нуурын голд Хэцүү цүнхээл гэж зард гарсан бэрх нуур байдаг юм. Томоороо ч гавихгүй л дээ. Нэг захаасаа нөгөө захаа хүртэл ердөө зуугаадхан л алхам. Жижигхэн хэр нь учиргүй гүнзгий, эргүүлэгтэй, дотор нь орсон хэрийн амьтан эсэн мэнд эргэж гарах нь ховор дуулддаг. Уг нь ус нь тунгалаг тогтуун дөлгөөн, ёроолын шаргал элс нь тун ойрхон мэт туяаран харагддаг. Дэргэдүүр нь янз бүрийн өвс ургамал алаглан ургасан, хажуухандаа нарийн ширхэгтэй зөөлөн элстэй, ёстой л амарч байгууштай сайхан газар байдаг юм.

Зургаан сарын аагим халуун ид шатаж байсан үе юмсан. Мятав хонь салхидаад хэцүү цүнхээлд үйчих вий, юмыг яаж мэдэх вэ гэсээр нуурын хойд ухаа дээгүүр гарч иржээ. Гэтэл бачимдсан хүний муухай орилох дуу гарч гэнэ. Тогтож харвал, нуурын усанд нэг хүн орчихсон үе үе шовсхийн, сарвалзаж байгаа үзэгдлээ. Мятав нэг мэдэх нь нуурын эрэг дээр ирчихсэн, «Одоо яана аа сүйд боллоо. Нуур руу орчихоор хамт өнгөрчих, гарт нь бариулчих гэхээр юу ч байдаггүй» гэж гаслан зогсож байв. Ядаж уснаас их айдгийг хэлэх үү, яадаг ч аргаа олохгүй нэг хэсэг болжээ.

Нөгөө хүн нэг ил гарч, нэг далд орж орь дуу тавьсан хэвээр. Дууны нь хүч улам суларч байхыг үзээд бүр ч их бачимдсан гэнэ. Улс амьтанд дуулгая уу гээд эргэтэл тэвдсэндээ болоод морио алдчихсан хөл залгаж хэл хүргэх унаа бүү хэл, гартаа барьсан шидэмсний тасархай ч үгүй хоцорсон байжээ.

Яана аа, өнгөрчихлөө л дөө гэж харамсан ийш тийшээ хартал бөөр алаг хүрэн бяруу нь оодгонон сүүл хатгасаар айсууг үзэнгүүт:

— Тэгдэг хэрэг, болдог арга! гэж дуу алдан бярууг амдлаа. Ялаа шумуулд хөөгдөн ухаан жолоогүй яваа бярууг ойртоод ирэхээр нь ухасхийн сүүлдэж барьж аваад тэврэн нуур руу гүйв.

Нуурын эрэг дээр ирж, нөгөө хүний ил гарч ирэхийг отож байснаа байдаг чадлаа шавхан бярууг нуурын тэг дунд чулуудчихлаа. Холхийх сүртэй чимээ гарч, Мятав цалгисан усны хүчит давалгаанд цохигдон ар тийшээ саван унажээ.

Долгио намдахаар эргэн тойрноо харсан чинь нөгөө хүн тэртээ эргийн шаргал элсэн дээр хэвтээ харагдлаа. Очтол нөгөө хүн амьсгаа авч жаахан уужраад

— Ус элс хоёрт үхэх шахлаа. Юу ч болов доо. Усанд сарваганаж явтал минь нэг хүн том алаг юм чулуудчих шиг болсон. Тэгсэн чинь ус хүчтэй палхийгээд би түүнээс үүссэн хүчтэй долгионд цохигдон шидэгдэж яаж ч чадалгүй элс рүү шаачхаад бүтэж үхэх шахлаа гэхэд.

— Арай дэндүү хүчтэй шидчихсэн юм болов уу даа. За яамай, яамай. Эрдэнэт хүний амь л мэнд гарсан бол болох нь тэр! гэж Мятав олзуурхан баярлаж суужээ.

Хүний золионд амь алдах шахсан бярууны хошуу үе үе цухалзан явсаар нуурын эрэг рүү огло харайн гарч усаа шилгээгээд ингэж сэрүүцдэг бол ч аюултай юм байна гэсэн янзтай эзэн рүүгээ харж байснаа ижлээ үгүйлэх мэт мөөрөн гэрийн зүг шогшиход Мятав:

— Ингэх л ёстой сон. Овоо шүү бөөр алаг минь. Монгол үхрийн эрдмийг ёстой нэг үзүүлж чадлаа даа гэж бахдан хайрлажээ.

## ХУСНЫ ШИД

Нэг өдөр Мятав малд явж байгаад Асгатын цохион дээрээс хэдэн тэмээгээ дурандаж суужээ. Тэр цохио бол хажуугаас нь хус мод шахан ургасан, гурав дөрвөн давхар байшингийн дайтай, тэрүүхэндээ өндөр гэгчийн газар байдаг юм. Хүрчигнэх сүртэй дуу гарахаар Мятав эргээд харсан чинь том алаг ирвэс ард нь ирчихсэн хэдхэн алхмын цаанаас үсрэн дайрахаар завдаж байлаа.

Хаашаа ч гарах газаргүй болжээ. Ирвэс биеэ хураан архирлаа. Мятав гэнэт цохионоос үсэрч өндөр хусны оройгоос зуурахад хус саван гулзайж нумарсаар Мятавыг газардуулав. Ирвэс хойноос нь үсрэхээс айн зүрхшээсэн янзтай өндөр хадны ирмэг дээр ирчихсэн балтайн хярж, Мятав руу хий л гөлөрч байв. Мятав «чамайг одоо» гэж шивнэн арайхийн тогтоон барьж байгаа нумарсан хусны үзүүрийг ирвэс рүү чиглүүлэн татаж байгаад тавьчихав. Хусны үзүүр чавхдан очиж ирвэсийг шавхуурдахад огцом муухай дуу гарч, амь тавьсан ирвэс өндөр хаднаас цоохор арьс шидсэн мэт газарт нэвсийн унажээ.

Ингэж Мятав халз тулгарсан араатны аюулаас ухаанаараа мултран гарсан түүхтэй.

\* \* \*

Би тэгээд манаач Өлзий гуайтай уулзсан юм.  
— Та найзынхаа тухай ярьж өгнө үү гэвэл:  
— Өөлөх юмгүй таван хуруу тэгш хүн. Хүний хийдгийг л хийдэг хүн дээ. Илүү гарна уу гэхээс дутна л гэж лав үгүй.  
— Яагаад адтай Мятав, ачтай Мятав гэж хэлэгддэг болсон юм бэ?  
— Яах вэ ажил үйлс, авхаалж самбаа нь хүн хүнээс гоц тасархай болохоор л тэгж нэрлээ биз.  
— Та тэгвэл ажил үйлсээс нь ярьж өгөөч.  
— Ах чинь бүгдийг нь мэдэхгүй. Улс амьтан янз янзын л юм ярьдаг юм. Би дайтаж явсан цагийнх нь явдлаас зарим юмыг өөрөөр нь яриулж, соронзон хальсанд бичиж авсан юм. Түүнийгээ л шууд сонсгочихъё. Чамд Мятавын явдал тийм хэрэгтэй юм бол Мөнхтэй уулзаарай л даа. Тэднийх одоо Борын хөндийд зусаж байгаа болов уу. Мөнх Мятав хоёр бас ч яггүй дотно, хэн хэнийхээ ажил явдлыг овоо гадарладаг л баймаар улс даа. Арай ч хоосон буцаахгүй байх гээд дуу хураагчийнхаа товчийг дарахад хэн нэгний эрдүү боргил хоолой сонсогдож намайг гялайлгасан билээ.

## ГАЙХАМШИГТ СОРОНЗОН

Эх орны минь эрх чөлөө, тусгаар тогтнолд гаднын аюул заналхийлсэн түгшүүртэй цаг үе байлаа. Дайсан манай хил рүү үе үе гэнэт уулгалан дайрч өдөөн хатгаж байсан юм.

Цэрэг болгон л дайн дажин, будлиан самуун, үхэл хагацал, ялсан дийлснээ ярьдаг байлаа. Шинэ цэрэг миний хувьд бол урьд өмнө ямар нэг үймээн будлианд оролцож явсангүй. Хүмүүсийн ярихыг сонсож суухад нэг үе тун ч аюултай юм шиг, нэг бодоход авхаалж самбаатайхан үзэлцвэл харин гавьяанд хүрч болмоор ч юм шиг, нэг үгээр хэлбэл, айж нэг үзэж, атаархаж нэг үзэж явсан цаг.

Намайг харуул манаанд гарсан хугацаанд юу ч тааралддаггүй байсан болохоор битүүхэндээ бардамнах маягтай. «Үгүй ер нь яадаг юм бэ? Цөөвтөр дайсан ирвэл ирэг. Хурдан буу үүрсэн эр хүн байна даа, үзэлцээд авахад яадаг юм бэ. Сэхээ самбаатай уужуухан байлдвал дийлж бололгүй дээ» гэж боддог байж билээ.

Нэг өдөр дөрвүүл манаанд гараад байтал дайсны машин дүүрэн цэрэг гэнэт гарч ирээд тарж хэвтэцгээлээ. Манай дарга нэг нөхрөө холбоо бариулахаар анги руу буцаалаа. Би тэгэхэд «Ашгүй намайг явуулаагүй нь яамай. Одоо л үзэж алдахгүй юм бол хэзээ цэргийн сургууль эрдэм хийснийхээ хэргийг гаргах юм бэ. За хөөрхий чиг сум тоолж өгнө дөө. Хорь гараадхан хүн ч юуны олон байх вэ дээ. Баатар болдоггүй юм гэхэд хариад нутаг усныхандаа ярих юмтай болж авъя. Эхлээд даргыг нь нухаад авдаг хэрэг ээ гэж бодоод битүүхэн баярласан юм шиг тушаал хүлээн анаж хэвтлээ.

Гэтэл дайсны талаас буу тасхийн, газар доргин, чих дүлийрч нүд харанхуйлаад явчих нь тэр.

Арай гэж харахад дайсны бууны ам харлан яг л амин газар руу шивчих гэж байгаа юм шиг үзэгдлээ. Хаагуур сум орчихдог бол гэхээс хуйх хөндүүрлэж, нурууны хүйтэн хөлс чийхарна. Дахин дахин буу тасхийн, толгойны үс хуйхалчих шиг боллоо. Яана даа,

хэцүүдэх нь. Босоод зугтах юмсан гэж дарга руугаа харсан чинь тэр ер сандарсан шинжгүй дайсан руу заналтайяа ширтэж байлаа.

Миний айж байгаа гэдэг зүйрлэж хэлэхийн аргагүй. Ингэж байгаад дайсны бууны идэш болох вий гэхээс ясны хөлс дааварлаж, ойр хавь оготнын нүх байдаг бол багтаад орчихоор санагдана. Эргэн тойрныг харахад хүний бие халхлах байтугай могойн зулзага нуугдах газаргүй, нүцгэн цагаан тал байх шиг бодогдож, арга ядан дахин ахлагч руугаа хартал хөмхийгөө зуусан хэвээрээ, «Доошоо хэвт!» гэж дохиж байв.

Хүний санаанд ганцхан агшинд хорвоо дэлхий бүхлээрээ багтдаг хойно доо. Би ч олон юм бодож амжлаа. Тулалдах гэдэг чинь юутай ч зүйрлэхийн аргагүй аюул юм даа. Энэ даргын ойртуулах гээд тайван байгаа, миний байж байгаа хоёр таарч дээ. Ээ гэгээн төрийн минь сүлд, яаж нэг мэнд гаръя даа хэмээн бодож хавчганан, ёстой тушаалын эрхээр газарт наалдаж байлаа.

Буу дахин тас тасхийн хоёр чих шуугин, толгой янгинаад хамаг биеийн мэдээ алдрах шиг боллоо.

— Одоо ч тэсэхээ байлаа шүү хэмээн шивгэнэж биеэ тэмтэрч үзэв. Дайсны ойртож байгаа гэдэг ч яриа алга. Бараг хүний зүс танигдахаар боллоо.

— Эргээд зугт! гэж гялайлгадаггүй юм болов уу гэж бодсоор дарга өөдөө дахин хартал, нүднийхээ булангаар сүртэй нь аргагүй хялавхийгээд дайсны зүг хөмхийгөө зуун ширтээр. Нөгөө нөхөр маань огт тэвдэж сандарсан шинжгүй, мөлхөж байгаа дайсныг бүртгэх мэт харсаар.

Миний энд л хэцүү газар таарч дээ. Ер нь би үхлийн шороо пурхийх газраа л олж хэвтсэнээс зайлахгүй. Даргын дэргэд ч очиж болдоггүй байгаа даа. Тэгвэл нөмөр түшигтэй, айхгүй буудалцаж болох байх шүү. Дарга намайг дуудахгүй, мөн хатуу сэтгэлтэй хүн ээ гэж бодож бас амжлаа.

— Галлаад! гэх даргын зандрангуй дуу хангинамагц буун дуу зэрэг зэрэг нирхийж, миний хэвтсэн довтог тэр аяараа хөдөлж, ойр хавийн шороо буцлан, газар тэнгэр нийлэх шиг болоход дотор муухайрч, зэвгэр бор хувцастай дайсан бүдгэрэн холдсоор харанхуй боллоо.

Гэнэт сэрвээнээс нэг юм угз татахад арай гэж нүдээ нээж харвал дарга дэргэд ирчихсэн

— Яаж байна? гэв.

— Яагаа ч үгүй, бие жигтэйхэн, яана аа даргаа!

— Шархтсан уу.

— Үгүй дотор аягүйцээд... Та намайг дэргэдээ... гэтэл

— Бүү ай, тэр мөлхөж байгаа дайсныг устга! гээд мөлхөөд явчихлаа.

Дайсан руу буюугаа онилох гэсэн чинь овоо хараа нь харагддаггүй. Барьсан мод үзэгдэхгүй мананд орчихсон юм шиг хамаг юм цэнхэртэн цийлгэнэнэ. Нэрэлхээд яах вэ, үнэн нь тэр юм чинь. Хэвтэж хэвтэж жаахан уужраад харсан чинь хоёр нөхөр маань огт тэвдсэн янзгүй онь холбон буудсаар. Дайнд эр хүн шалгардаг юм гэнэ лээ. Ийм л улс гавьяа байгуулдаг байх. Баатар болно гэдэг чинь над шиг хүнд зүүдэнд багтамгүй ажил юм гэж бодон нааш мөлхөж буй дайсан руу хий л гөлөрсөөр байв.

Гэнэт дайсны хэдэн хүн эргээд зугтлаа. Тэгэхлээр нь эр хүн байна даа, буудъя байз гээд зориг орж хойноос нь хэд буудаж билээ. Одоо бодоход ниргэсний дараа хашхирах гэгч, нөгөө үгээр хэлбэл, сүүгүй хонь холбоосог гэдэг л тэр болжээ.



Бидний араас туслах хүч ирсэн юмсанж. Бид гурав зүв зүгээр. Дарга нар, найз нөхөд баатарлаг тулалдсан гэж биднийг магтана. Хожим ухаан ороод үзсэн чинь нээрээ л дайсны тэн хагасыг цааш харуулсан байж билээ.

Зоригтой эрэмгий түмэн эрийн дунд над шиг мулгуу эр өдрийн од шиг байдаг биз.

Хань бараа л болж байсан байх даа. Түүнээс биш миний хувь нэмэр гэж юу байх вэ дээ. Тэр хоёрын л гавьяа юм чинь. Гэгээн төрийн минь сүлд, сайн нөхдийн баатарлаг үйлс, ач гавьяа л амийг минь аварлаа гэж халаглан үглэх шахаж, болж өнгөрсөн байлдааныг бодохоос өвдөг чичрэн магнайны хөлс чийхран байлаа.

Ахлагч маань толгой сэгсрэн жуумалзаж аядуун зөөлөн дуугаар

— Мятав аа, дайтах ямар байна даа? гэлээ.

— Ярих юм биш дарга минь, арай л газрын хөрстэй хамт эргүүлчихсэнгүй гэж хэлэхэд хоолой чичирч, нүдний нулимс бүрэлзэж байв.

Оройхон дарга нар бүх цэргийг жагсаан, болж өнгөрсөн тулалдааны тухай, манай эрэлхэг гурван нөхөр амжилттай байлдаж дайсны арав гаруй цэргийг устгасан тухай сонсгож, бидэнд баяр хүргэн хөхүүлэн шагналаа.

Би юу ч хороож амжаагүй хүн шүү гэж хэлэх гэснээ насных байсан юм бол уу даа, нөхдөөсөө ичээд ам эвлэж өгөөгүй юм.

Миний хувьд найман цагийн чөлөө хүнддэх том шагнал. Манай хоёрыг баатар болгосонгүй шүү. Ийм улсад өгөхгүй байгааг бодоход баатар болно гэдэг ч барагтай аавын хүү давдаг даваа биш юм аа. Би юу гэж бодож явлаа. Даан ч ичгэвтэр юм бодож байжээ. Дур эзнээ голдоггүй гэгчээр мөн ч том санаатай явж шүү хэмээн өөрийгөө зэмлэж байлаа.

Цэргүүд нам гүм унтжээ. Өдөр дайсантай тулалдсан хоёр нөхөр ч бусдын адил нэгэн жигд тайван хурхирна. Би элдвийг бодон хөрвөсөөр. Дарийн эхүүн үнэр, гашуун утаа хамар аманд шингэчихсэн, чих дүлийрэн шуугьсан хэвээр.

— Үзээгүйгээ үзлээ. Төрийн минь сүлд гэж шивнэснээ «яана аа» хэмээн өөрийн эрхгүй чанга хэлчхээд түүнээс айн цочиж бөндгөсхийснээ ёх, ёх яаж тайвширдаг юм билээ. Хүн яахаараа ийм их зориг зүрхтэй амгалан тайван байж болдог юм бол. Энэ хоёрын хурхирч байгааг.

Дайтаж эхлэхээр ч орох нүх сүв олдохгүй, яаж ч болдоггүй эд юм. Эрдэнэт хүний амь хутганы ирэн дээр л байх юм билээ. Золтой хяргуулчихсангүй шүү. Дараагаар яаж харуулд гарна аа!

Дайсны буудсан сумыг нэг газар л тусгадаг, хүнд болон биедээ хавьтуулдаггүй ид шидтэн ч болоосой хэмээн бодлогоширч хэвтсэнээ гэнэт нэг бодол тархинд харваж орлоо.

Тэгдэг хэрэг! хэмээн өөрийн эрхгүй уулга алдан өндийгөөд суучхав. Буцаж хэвтээд түүнийг барьж явсан цагт дайсны сум биед тусна аа гонж. Бүх сум түүн дээр л шавчихна. Сум чинь төмөр! Төмөр болохоор соронзон ховх сорчхоод байх нь гарцаагүй гэх мэт элдвээр эргэцүүлэн бодож бодож

— Ёстой ухаан! Найман цагийн чөлөөг үүнд л зориулна. Түүнийг маргааш олохдоо л олно гэж шивнэв.

Дайн тулалдааны тухай зүрх үхүүлсэн бодол хоног хоногоор замхран арилж байв. Хэд хэдэн удаа харуул манаанд гарч, бас ч хоёр гурван удаа жижиг тулалдаанд оролцож, дайснаас ганц нэгийг цааш харуулдаг боллоо. Орж байх газар олдохгүй тэвдэн сандарч хөглөж байснаа бодоход хал дол үзсэн хуучин цэрэг болжээ. Эр хүн хэцүү бэрх цагт хатууждаг гэж үнэн шүү.

— Байлдагч Мятав тушаал хүлээн авахад бэлэн үү? гэж хороон дарга сүртэй асуухад

— Ямар ч тушаал биелүүлэхэд байлдагч Мятав би бэлхэн! гэж хариуллаа.

— Бид сая тагнуулын мэдээ хүлээн авлаа. Хэсэг дайсан хилийн ойролцоо ирж буудалласан байна. Хүн хүч зэвсэг техникийн тоог мэдэн, амьд хэл олзолж ир! гэж тушаахад

— Мэдлээ, нөхөр хурандаа, гүйцэтгэе гэж ёсоллоо. Тушаал авахад бага үд болж байсан юм даг. Би заасан газрыг чиглэн явж барсгар хадтай толгойд нуугдан харанхуй болгохоор шийдлээ. Дайсны байрлалыг дурандвал хоёр машин цэрэг бололтой жар орчим хүн хоноглохоор шийдсэн янзтай оромж босгож байлаа. Оройн бүрий болтол эндээ хүлээхээс өөр аргагүй. Тагнаж мэдэх, амьд хэл олзлох тухайгаа нэгд нэггүй нарийвчлан бодлоо. Тийм ч амар үүрэг биш. Яаж биелүүлдэг хэрэг вэ гэж удтал эргэлзэв. Олигтой юм санаанд орж өгдөггүй шүү.

Цаг дээрээ тулахаар учир нь олдоно биз гээд ширхэг ч үүлгүй цэлмэг хөх тэнгэрийг харж хэсэг хэвтлээ.

Өссөн нутаг, аав ээж, ах дүү, нутаг усныхан, хурдан явдалтай морьд, цэрэгт мордсон, хилд ирсэн, анхны тулалдаан цөм ээлж дараалан санаанд урсан орж ирнэ.

Гэнэт өөрийн эрхгүй инээд хүрч,

— Нээрэн тэр нэг төмөр! Их ажил болсныг яана аа. Бараг өдөржин эрсэн шүү. Тэгсэн хэр нь хэрэглэдэггүй, хэрэглээгүй нь ч болж, амьтны доог болж нэр нүүрээ хөөдөх байснаас зайлахгүй. Мөн ч тэнэглэж байжээ. Их айсных л юм байх даа. Биедээ сум хавьтуулахгүй, соронзонд татуулна гээд түүнийг тэвэрчихсэн харайж байсан бол ч өдийд муу Мятав олон даяар хөгөө дэлгэчихсэн байх даг шүү. Цэрэг болгон л захиандаа бичнэ дээ. Аа-яа-яа гэж толгой сэгсрэн биеэ тавиртал хөхөрлөө.

Яахаараа тийм юм ухаанд орсон шүү болсон юм бол доо. Хүчтэй соронзон ч нээрээ бууны сум нь юу юм бэ, хэрийн төмрийг үлдээхгүй ховх сорчих байх шүү гэж бодтол гэнэт шинэ арга сонин бодол тархинд минь зурсхийн орж ирлээ.

— Ёстой догь. Яг болно. Хуу татуулна хэмээн би өөрөө мэдэлгүй дуу алдав.

Яаран явж, зориудын эрэл болж байж олсон «учиртай» төмрөө булсан тэмдэгт газраа очин тогоон тагийн чинээ дугуй төмрийг малтан гаргаж ирээд түүнийг юунаас ч илүү нандигнан байлдагч эрийн ширүүн гараар энхрийлэх адил илж, «За хө чи бид хоёр ч тэднийг ганц болгож өгнө дөө. Яг болно!» хэмээн ганцаараа ярьж суулаа.

Дугариг том төмөртөө бат бэх оосор хийлээ. Үүрч үзсэн чинь биед эвтэйхэн байгаа гэдэг яриангүй.

Оройн цагаан гэгээ тасарч, үдшийн бүрий болох үед би товлосон газраа аль хэдийн хүрч, дайсны байдлыг ажиглаж, чимээ чагнан хэвтэж байлаа. Шөнө дундын алдад тэд цөм унтав бололтой, таг чимээгүй боллоо. Хааяа чимээ өгч байсан манаач ч мөн таг чиг болов.

Дуу чимээ гаргахаас болгоомжлон мөлхсөөр зуны айлын чинээ ирлээ. Амьсгаагаа дарж чагнахад нам гүм хэвээрээ. Хааяа хүний яраглах нь дуулах бөгөөд цөм бөх унтсан шинжтэй. Нэг хүн босоогоороо үе үе дунхагас хийнэ. Тэр манаач нь бололтой.

Харанхуйд нүдээ дасгасаар ойртвол оромжийн хойхно сарайж сэрийсэн юм харагдлаа. Бие биеийг нь түшүүлээд тавьчихсан буу байхыг үзээд, хэрэг болбол ганц ухасхийгээд л нэг дор тавьсан зэвсгээ түвэггүй авах нь байна шүү. Айхавтар мондиуд гэм. Энэ чинь надад л сайн хэрэг. Амттай хоол бэлтгээд тавьчихсан л гэсэн үг. Эдгээрийг минийх гэж тооцъё. Салгаад авчихсан хойно тоо нь аяндаа мэдэгдэнэ.

За даргын тушаал чинь хүн, зэвсгийн тоо, амьд хэл!... Өдөр тоолоход яг л жаран гурван хүн байсан. Энэ болно. Бууны тоог мэдэх төдийгүй цөмийг нь... Хамгийн хэцүү юм амьд хэл! Яах вэ байз. Энэ үүрэглэсэн манаачийг л эрхэндээ оруулах хэрэгтэй, чухам яаж өөрийн болгох вэ. Мөлхөж очоод дуу гаргалгүй бариад авна гэж бодъё. Үгүй ээ. Тэгэхлээр нөгөө чухал юмаа үүрэхийн оронд аманд нь алчуур чихэж, хөл гарыг нь хүлсэн хүн үүрэх болно. Ингэж болохгүй ээ. Миний ачаа ердөө хөнгөдөхгүй. Яая даа байз. Эр хүний дотор эмээл хазаартай морь багтдаг гэдэггүй билүү. Ганцхан л арга хэрэгтэй сэн гэж өөрөөсөө ухаан шаардаж хэсэг ажиглалаа.

Гэнэт манаач буугаа барьсан юм уу, мөрлөсөн үү, үүрсэн үү гэдгийг мэдэх хэрэгтэй боллоо. Яльгүй ойртоод хартал үүрэглээ манаач буугаа бүр лав үүрчихсэн, түүгээрээ түшиг хийгээд ганхаж ч байгаа юм шиг.

За, хэргээ бүтээж болно. Одоо шийдсэнээ хийх цаг боллоо гэж бодсоор босож зогслоо.

Мятав минь одоохон эхлээч гэх шиг эх нутгийн зүгээс урьхан салхи сэвэлзэнэ. Догдлон байгаа сэтгэлээ дарж, бодсоноо хийхээр шийдэж оосрыг нь шалгаад соронзонгоо үүрлээ. Татдаг талыг нь сарайж сэрийсэн бөөн бараан юм руу харууллаа.

Мод төмөр харшлах төдийхөн чимээ гарснаа, өнөөх олон буу хоромхон зуур ирж соронзонд минь наалдчихлаа. Сарайж сэрийсэн бараан юмны оронд овойж торойх хумсын чинээ ч юм үлдсэнгүй. Ховх сорчихжээ!

Юу ч болтугай цөмийг чинь гарыг мухарлалаа.

Одоо манаачийг нь соруулах цаг болж гэж шийдээд цаашаа хараад дунхагнаж байгаа манаач руу соронзонгоо харуулав.

Би ч ангийнхаа зүг шогшиж гарлаа. Ачаа үүрэг ч зэгсэн хүнд болжээ. Эргэн харвал манаач эрийн буу соронзонд аль хэдийн наалдчихсан, эзэн нь бууныхаа оосрыг мултлах санаатай сарвалзаж байлаа. Бас цаашаа зүтгэж үзэж ч байгаа бололтой.

Манаач арга нь барагдсан бололтой муухай ориллоо. Тэр дуунаар дайсны цэргүүд шулганалдан хашхиралдаж эхлэв.

Би ч түүнд бууныхаа оосроос мултрах завдал өгөлгүй явдлаа арай хурдатгаж байлаа.

Дайсны муухай орилолдож хашхирах чимээ улам бүр холдсоор. Гахай явган, нохой нүцгэн барьсан модгүй тэд яав л гэж дээ хэмээн инээд хүрч байж билээ.

Хүн гэдэг амьтан айхавтар шүү! Нөгөө манаач чинь орилж нэг үзнэ. Зүтгэж нэг үзнэ. Сарваганаад л байгаа бололтой. Ярдаг эр байж билээ. Ар тийшээ татагдаж яваа хүн чинь унахгүйг хичээж зөвхөн тэнцэж байхын хүслэн болж явдаг юм билээ. Эргэх гэхээр уначих гээд яаж ч чадахгүй явааг би бүр түүрүүнд мэдсэн юм.

Тэр буугаа давчуу оосортойг мэдэхгүй даанч лав үүрсэн байсандаа л миний олз болсон юм. Өсөхөөсөө морь уургалсан би өдөр туршин үзэж байхдаа яаж ч улавчилж суугаад тогтоогоогүй юм. Ийм айхавтар хүчтэй татагдахыг анх удаагаа үзэж байгаа хүн ч яаж тогтоох вэ дээ. Тэгэхдээ тун хөл сайтай эр байсан санагддаг юм. Муухан эр бол муухай орилоод хүрчигнэтэл чирэгдэж ачааг минь хүндрүүлэх байсан. Тэр тэгээгүй юм шүү!

Би соронзонгийн гайхамшигтайд урамшин зоригжсоор баяр хөөртэй, их олз омогтой ангидаа эсэн мэнд ирж, тушаалыг ёсчлон биелүүлснээ даргадаа илтгэсэн юм. Цэрэг, цэрэг чигээрээ төрдөггүй гэдэг үнэн юм шүү.

\* \* \*

Би Өлзий гуайн зааснаар сураглан явсаар хоньчин Мөнхтэй уулзлаа. Тэр өдөр Мөнх гуайн хонины ээлж таарчээ.

Намхан цэнхэр уулсаар эргэн тойрон хүрээлэгдсэн өргөн Хөндийн хойд биед байх ухааг бүрхэн соргог сэрмүүн бэлчээрт хонин сүрэг тавтай идээшилнэ. Тэнүүн талын дундах холбоо нуурын захаар адуу мал багшран бараантаж үзэгдэх бөгөөд тэндээс нэлээд зайдуу байх цагаан гэрүүдийн яндангаас шингэн цэнхэр утаа баагьж, гүүн зэл орчимд унага даага тонгочин давхилдана.

Голын эрэг даган хэд гурваар тархан буусан айл саахалтын хооронд морьтой багачууд хөндлөн гулд давхилдаж хаа нэгтэйгээс үхэр мөөрөн адуу янцгаах нь хүүхэд багачуудын цовоо шингэн дуутай хослон сонсогдоно.

Энэ бүхнийг сониучлан цэвэр цэнгэг агаар, түмэн зүйлийн ургамлын үнэр танарыг таашаан явах юутай бахтай. Ай тэнүүн жаргалант түмэн амгалан монгол эх нутаг минь. Цагийн сайхан дэлгэр зуны эхэн сар, газрын сайхан хөдөө нутгийн уужим хөндий.

— Та Мятав гэдэг хүнийг таньдаг уу? гэж Мөнх гуайгаас асуулаа.

— Адтай Мятав гэж нэг танил бий. Аавын цээж Мятав ч гэж бас бий. Аль нь юм бол доо?

— Мэдэхгүй, их эртэй зоригтой, лут сэдээч, ухаалаг хүн юм гэнэ дээ.

— Өө тэгвэл адтай Мятав гарцаагүй мөн. Түүнтэй дүйх арга ухаан, авхаалж самбаатай аавын хүү ч ховор шүү. Өөдлөхөд санах сэдэх гэж үг байдаг даа. Түүнийг бүрэн эзэмшсэн хүн бол Мятав л байгаа юм.

— Та тэр хүний явдлаас ярьж өгөхгүй юу?

— Би мэддэгээ ярьж ч болно оо. Чи юу боловч Эрдэнэтэй уулзаарай. Тэр Мятавтай нийлж олон жил ан гөрөө хөөсөн хүн дээ. Санаанд нь хэд гурван юм бий байх. Хүү минь, Өвөр жаргалантыг мэдэх бил үү? Тэднийх тэр хавьд л байгаагаас зайлахгүй гээд хэсэг бодлогоширсноо

— За даа би ч тун мунгинуу хүн дээ. Бодоод байхад түүний ярьснаас хоёр гуравхан юм ухаанд минь үлджээ.

## НЭГ СУМААР ХОЁР ЧОНО

Мятав цахиур буугаа үүрчхээд нэгэн халуун өдөр уулын хэцээр хэрж явжээ. Чулуу хүртэл данхтай халуун цайнд гараа хүргэсэнтэй адил улайдсан жин үдийн халуун болов.

Морио чөдөрлөчхөөд хадан дэл дээгүүр өнгийтөл ойролцоохон хоёр том чоно халуун наранд нам цохиулсан мэт тэрийн хэвтэж байлаа. Хар авхуулчих вий гэхээс буцаж болдоггүй, байж болдоггүй яг гацчихлаа.

«Буруу газраас л өнгийчихлөө. Тэр зүүн дэл дээрээс гарч ирсэн бол нэвт буудчихад болохгүй гэх газаргүй юм. Яадаг хэрэг вэ, зүүн дэл өөд мөлхдөг юм бил үү? Яршигтай юм даа, энэ халуунд, ...Нэгийг нь буудахаар нөгөөг нь алдчихна. Цахиур буу цэнэглэх хооронд хэдэн уул даваад талийна» гэж бодлоо.

Тэгснээ халуун наранд элгээ маарштал дэмий хэвтэж байхаар хоёулыг зэрэг агнах арга сүвэгчилдэг хэрэг ээ гэж ажиглаж гарлаа. Гэв гэнэт тэмээний хорголын чинээ бөв

бөөрөнхий чулуу хоёр чононоос наахна тэгэхдээ нэгэнд нь нэлээд ойрхон байгааг үзэж аргаа дорхноо оллоо.

Юу ч гэсэн муужиртал нь дэлсчихмээр овоо шаг хийсэн эр чулуу бололтой. Сарьсан хоншоор дээр нь тааруулсан байхад ч учир бий. Суманд бол огт санаа зоволтгүй. Замдаа нэг хүч аваад л хулхиар нь орчихно.

Нар тусаж байгаа тэр гялгар бөөр дээр бол «нимгэднэ». Наад бараан хэсэгт баривал «зузаадна». Тэр гялгар бөөрөнхийн наад амсарт бол яг таарна. Сум бөөрөнхий, чулуу бөөрөнхий! Бильярдаар бол яг л хоёр буланд гэсэн үг.

Товлосон газраа шагайн гохоо атгалаа.

Шаг хийх яхир чимээ дуулдсанаа пүд, таг хийх дуу зэрэг гарч, хоёр чоно умираад явчихлаа.

Чулуунд оногдож муужирсан чононд гүйн хүрч, муу хийж аваад нөгөөдөх дээр нь ирвэл сум яг хулхинд нь туссан байжээ.

Мятав ингэж нэгэн сумаар хоёр чоно агнаж, ганзагаа мялаасан удаатай. Ангийн тэнгэртэй яваа хүнд ч арга ухаан дорхноо олддог юм билээ.

## УТАС ОЛСНООС ХҮЧТЭЙ

— Мятавын явдлаас үзсэн өөр юм байна уу Мөнх гуай?

— За даа өөр юм үгүй шив дээ.

— Ингээд л болох гэж үү?

— Харин ээ юу сан билээ. Аа тийм. Манай муу идэмхий солби шарыг... гэж тодхон хэлээд инээн ингэж ярилаа.

Хэдэн жилийн өмнө юмсан. Манайх нүүж явлаа. Өвөр Жаргалантын голоор нүүдэл маань гарах болов.

Хэсэг, хэсэг булагнаж ногоорон эргэлдсэн хэцүү бэрх тохой цүнхээл элбэгтэй энэ голыг гармыг нь олж гарахаас биш дуртай болгон санааныхаа зоргоор гаталж амждаггүй билээ.

Ачааны түрүүч голын нөгөө эрэг дээр гарч байтал цаанаас Мятав хатирдаг хээрийгээ уначихсан хүрч ирэв ээ. Амар мэндээ мэдэлцээд:

— Хаа хүрээд буцаж явна аа гэж асуувал

— Агентынд очиж аахар шаахар юм аваад л явж байна гэлээ. Ачааны хамгийн сүүлд явсан, хоёр хөхүүр айраг ачсан солби шар тайлаг голын тэг дунд орж ирснээ бурантгаа тасдуулан сууж үлдээд, ийш тийшээ харж байснаа ингээд л дүүрье гэсэн аятай муухай орилон дайвганасаар ойчоод өглөө.

Амыг нь сайн боож тэгнэсэн хөхүүртэй айраг усанд живж орохгүй байгаагаас шар тайлаг доошоо ч ордоггүй, хөллөөд босож ч чаддаггүй өөөдчихсэн бололтой, аврал гуйсан нүдээр биднийг ширтэн сэвсээрээ булан орилсоор усны урсгал даган хөвж эхэллээ.

Ачаатай тайлаг гармаас аль хэдийн холдож ойртон очиж болохооргүй, ус нь ногоорон эргэлдсэн том цүнхэлд хүрч, наашаа ч үгүй, цаашаа ч үгүй болоод усны эргүүлэг даган өөрийн эрхгүй эргэлдэн хөвсөөр. Би хий бухимдан:

— Ээ, малын шаар! гэж хараал тавьж, хөж! хөөг! хэмээн дороо дэвслэн хэчнээн хашхичсан боловч огт нэмэр болсонгүй.

Мятав:

— Тэмээ усанд мууг хэлэх үү, энэ одоо босохгүй ээ! Эргүүлэгт орчхож, гарч ирэх горьдлого тасарлаа л даа гэв.

Би яадаг ч аргаа олохгүй, улам цухалдаж

— Ийм дүүрсэн мал гэж байдаг аа. Бусад нь гармаар давгүй гарчхаж байхад... Даавуу хэмлэхээс өөр идгүй, заяагүй мал байх гэж яая даа та минь, Дүүрлээ л дээ гэтэл Мятав:

— Энэ чинь тийм их идэмхий мал юм уу? гэлээ. Би ч тэр тайлгийг муучлахад үг хайрлахгүй гэсэн шиг.

— Яриа юу байх вэ? Дүүрчихсэн идэмхий золиг байгаа юм. Энэ яваа насандаа уранхай тасархай даавуу урдуураа зүгээр өнгөрөөж огт үзээгүй амьтан! Тэмээ сэжигч амьтан, харин үүнд эрээлэх юм гэж даанч байхгүй дээ! хэмээн хэлж орхилоо.

Мятав «Өөр аргагүй» гэж шийдмэг хэлээд өврөөсөө оёдлын машины утас гаргаж нэлээд хөвснөө тэрэгтэй утсаа тэмээ рүү шидээдэхлээ. Тэрэгтэй улаан утсыг дэргэдээ буунгуут идэмхий шар ч мэргэжсэн минь энэ гэсэн шиг үмхээд авах нь тэр.

Яаж байгаа юм бол доо гэж гайхшаа баран ажиглаж зогстол Мятав утасныхаа үзүүрээс угз татан цааш алхлаа. Идэмхий шар тайлаг ч хөвсөн янзаараа чирэгдэж эхлэв. Мятав нэлээд явж тогтуухан ногоорон эргэлдэгч эргүүлэгт тохойноос орилоо шарыг гаргах зуураа голын эргийг няхуур ажиглаж байгаад усны урсгал сөргөн гармын зүг ачаатай тайлгийг дураараа хөндлөн гулд чирч гулдарч явлаа.

Идэмхий шар тайлаг учрыг олоогүй хэр нь таатай байгаа янзтай, хялгас төдий үл ялих нарийхан утсанд ачаа бараатайгаа цуг чирэгдэн, усны урсгал сөрж яг л усны шувуу аятай хөвж яваа үзэгдлээ.

Миний гайхсаныг хэлээд баршгүй. Гараад ирлээ шүү гэж бодохоос баярласан гэдэг учиргүй.

— Үгүй мөн хачин аа! Муу солби шар минь элдэв даавуу шувуу үлдээдэггүй хамж иддэг үнэн идэмхий амьтан гэсэндээ тэрэгтэй утсыг овоо үмхэж шүү гэж үглэл бухимдал маань инээдээр солигдов.

Солби шар тайлаг уснаас гараад юу болов доо гэсэн маягтай усаа сэгсэрснээ аманд орсон дээр нь... гэсэн шиг тэрэгтэй утсыг ховдоглон хүлхсээр бусад тэмээ рүүгээ очиж билээ.

— Үгүй бас хачин юм даа. Мятав аа, тайлган тэмээг ачаа бараатай нь хамт оёдлын машины утсаар чирч их уснаас гаргана гэдэг санаанд багташгүй юм шүү. Аль вэ наад утсыг чинь үзье гэвэл Мятав нэг их гоц гойд юм боллоо гэж бодсон янзгүй.

— Үз л дээ. Юм оёдог жирийн л утас шүү дээ гээд надад утасныхаа нэг хэсгийг түвэггүй тасдаж өгснөө

— Усанд хөвсөн бие их хөнгөрдөг гэж ярилцдаг байх аа! гэж байсан юм шүү.

\* \* \*

Биеийн тамирын ордны өргөн цэлгэр танхимд хүмүүс пиг дүүрсэн байв.

Таван ханатай гэрийн буурины чинээ дэвжээн дээр өндөр гулзгар хүн, намхандуу лагс биетэй залуу хоёр ач тач ноцолдон дээр дороо орж годройтон дунгуйлдах боловч хэн нэг нь оноо авч чадахгүй байлаа.

Нэг нь өрсөлдөгчөө өргөөд чулуудсан чинь нөгөөх нь унахдаа хөлийг нь хаман дарж ойчлоо. Өндөр гулзгар эр ганц горьдлого маань энэ боллоо гэсэн мэт байдаг чадлаараа нумлалаа.

Намхан нуруут ч ийм болгоод алдчих вий гэсэн янзтай анаж, байдаг чадлаараа дарсаар. Өрөөсөн дал нь дэвжээнд хүрлээ.

— Уухай дараад бай, дараад бай хэмээн танхим дүүрэн шуугиан боллоо.

Өөөдсөн мэт хэвтээ залуу шүд зуун гэдийж, дээр нь байгаа эр байдаг тамираа шавхан чээжээрээ дарсаар... Дарж даруулж байгаа шинжгүй, огт хөдлөлгүй хүч нь яг тэнцэн нэг л хэвдээ. Цагаан хувцастай шүүгч хэрхэхийг отон цаана нь ажигласаар. Олны учир тоймгүй шуугиан үргэлжилсээр. Гэнэт хурган дотортой хүрэн торгон дээлтэй ануухан өвгөн суудлаасаа босож:

— Дараад нэмэргүй, тэнхээний гарз. Хөлийг нь солбиод гэж хуруугаараа зааж хэллээ.

Бөх ч санаа авсан мэт баруун хөлийнх нь доогуур гараа хийж цаад хөлөөс нь зугуухан татлаа.

— Зөв зөв. Одоо чээжээрээ сайн дар! гэж өнөөх өвгөн хашхирна.

Шүгэл тасхийн, учиргүй шуугиан нижигнэсэн алга ташилт болж хувирлаа.

Тэр өвгөн чинь хэн сэн билээ, үзсэн хүн шиг. Унжуудуу хамар, урт эрүүтэй, сэргэлэн хурц нүдтэй, амьдралын олон он жилийн хугацаанд хал дол үзсэнийг гэрчлэх мэт хэдэн гүн үрчлээ суусан өргөн сайхан магнай, тэгш сайхан шүд бүхий, чээж тэвхгэр зузаан, залуудаа сайхан эр явсан болов уу гэмээр янхигардуу чацархаг биетэй, хөнгөн шингэн, нүдэнд дулаахан сайхан өвгөн байх чинь. Хаана үзлээ?

— Аа тийм. Мятав гуай байна. Яг дүрээрээ мөн гээд би тэр хүн рүү олны дундуур дайрлан зүтгэлэв. Хүн амьтан замд тээглээд ер явж болдоггүй.

Нэг харсан чинь Мятав гуай бах нь ханасан янзтай инээж хажуугийнхаа хүнтэй ярилцаар хаалгаар гарч явлаа.

— Хөөе Мятав гуай гээд би байдаг чадлаараа хашхиртал

— Сэрээрэй залуу минь гэсэн бүдүүн баргил дуу гарч, хөнжлөөс татаж байлаа. Би зүүдэлжээ. Хайран зүүд гэж харуусан өндийтөл өчигдөр эрэлд яваад ирээгүй байсан Эрдэнэ гуай аль хэдийн хувцаслачихсан цай уун сууж байв. Би нэгд зүүдэлж хашхирсандаа, хоёрт Эрдэнэ гуайг шөнө ирэхэд нь сэрээгүйдээ бантан ичингүйрхэн шуухитнан хувцаслалаа.

— Аль хэр амрав даа. Арай эрт сэрээчхэв үү дээ. Цай уу, гээд Эрдэнэ гуай миний өмнө тавагтай өрөм тавьж цай аягалж өглөө.

Эрдэнэ гуай цай уух зуураа:

— Өчигдөр хэдэн тэмээгээ харж гадуур жаахан яваад олсонгүй. Өнөөдөр дахиад л шогшихоос доо. Манайхан чамайг надтай уулзахаар ирсэн гэж ашгүй надад түрүүхэн хэллээ. Золтой л унтаагаар чинь орхичхоод мордоод явчихсангүй гэм. Хот газрын хүнийг хэлэх үү, нас залууг хэлэх үү, нойртой байлгүй яах вэ гэж миний бантаж байгааг мэдсэн янзтай хэллээ.

— Би танаас ганц нэг юм асуух л гэж ирсэн юм. Та яаруу ажилтай байгаа бол хамт мордоод замдаа яриулсан ч болох л доо гэж намайг өгүүлтэл:

— Хүн уулзахаар зориуд ажил болж ирж байхад хаанаас тэгж болох вэ? Ах чинь хэрэгтэй бол хэдэн тэмээндээ маргааш явсан ч болох шүү дээ гэлээ.

— Яльтай ч юм биш ээ гэж би түгдэрснээ: — Та Мятав гэдэг хүнийг таньдаг гэл үү? гэж асуув

— Ямар Мятав?

— Адтай Мятав

— Танихаар барах уу даа...

Эрдэнэ гуай босож айргаа бүлснээ шуугин байгаа хөхүүртэй айргаас хувинд уудлан өмнө минь тавив.

Би сэнгэнэсэн сайхан айргаас аягалан залгилж:

— Та Мятав гуайн ажил явдлаас надад ярьж өгөөч гээд учирсан хүмүүс, тэдний ярьсныг товч хэлэхэд Эрдэнэ гуай:

— Үнэндээ хөөрхий, яг л тэгж ярьдаг юм. Чи өөртэй нь уулзахыг бодоорой. Охин хүү хоёр дагаж хөгшинтэйгөө хот ороод хэдэн жил болж байгаа юм. Мятавын ярьснаас би хоёр юмыг нь л сайн санаж байна. Түүнийг түрүүчийн улс чамд яриагүй боллолтой. Миний хувь болгож үлдээсэн юм байлгүй дээ гээд инээв.

— Ээ дээ, түүнийгээ л гэж би дуу алдав.

## МЭХЭЭРИЙН АМТ

Хэдэн хурга шингэнээр гүйлгээд болдоггүй. Мэхээр сайн юм гэнэ гэж дуулаад Мятав ойд очиж, оготно хөөлсөн жаахан мэхээр олоод, багадуулж хэлбэл үдийн газар, бадруулж хэлбэл хоногийн газар ирсний хэрэг юу билээ, ахиухан байвал зүгээр ч юм уу гэж санан ой дундуур хэрэн бэдэрч явжээ.

Тэгсэн чинь нэг их том баавгай идэш хайсан янзтай огт сэжиг авалгүй явж байгаа үзэгдлээ. Яадаг хэрэг вэ? Буу ч байна, сум ч байна, цааш харуулчихдаг хэрэг үү гэж хэсэг эргэлзлээ.

Мориноосоо буун бугаа шийрлэх зуур энд нь нударчхаж болно. Харин түүнийгээ яаж гэр өөдөө дөхүүлдэг хэрэг вэ? Алахаасаа өлгөх нь... гэсэн бодол орж ирлээ.

Нээрээ тийм, бараг сум сунган аймаг алгасан гэр орноосоо зайдуу яваа ганц хүн энэ том амьтныг алахад амины нь гарз юм гэж эргэлзэн буудахаа болилоо. Яаж гэр өөдөө дөхүүлье дээ. Туултай биш, дуудалтай биш хэмээн санаж санаж нэг арга олов.

— Гарцаагүй бүтнэ гэж шивнээд шалавхан мордож баавгайг амдлаа.

Үүгээр л ирнэ шүү дээ гэж бодон ойн нэгэн цоорхойд мэхээртэй хүүдийгээ энд тэнд нь жижигхэн жижигхэн тэгэхдээ гоожчихооргүй цоочлоо.

Ганзагалж явсан арваад алд сурынхаа үзүүрээр амыг нь сайн боочхоод хол оо очиж, нөгөө үзүүрээс нь барин тэр том амьтны хэрхэхийг ажиглаж байлаа. Баавгай явсаар нөгөө ойн чөлөөнд ч гарч ирлээ. Ер сэжиг авсан янз алга аа! Үзэхгүй явчихна уу даа, энэ монди чинь гэж шивнээд хэсэг харлаа.

— Алхаад өнгөрөх нь шүү. Баавгай ижилгүй тэнэг гэдэг нь үнэн болж таарлаа гэж бодуут сураасаа жаахан жаахан угзчив.

Баавгай гэнэт зог туслаа. Амь голтой юм шиг татав татав, ухас ухасхийж байгаа тэрхүү ер бусын «амьтныг» сонирхсон эгдүүцсэн янзтай ширтэж байв. Мятав ч угзчихаа



больжээ... Баавгай адтай хөдөлж байсан хачин «амьтан»-хүүдийг гайхсан янзтай ажиглаж, залхуутай тэгэхдээ хянуур нь аргагүй түүнд ойртлоо. Бүр очоод шинжиж гарав аа. Тэгснээ хүүдийг долоож эхлэв. Сайхан амттай хоолтой учрав гэсэн янзтай ийш тийшээ харснаа ум хумгүй долоолон хэл амаа билүүдэх нь аргагүй дуртай юмтайгаа учирсныг гэрчилнэ.

Болдог сон бол бүхлээр нь залгичихмаар байгаа бололтой. Гэвч аманд нь олигтой юм орж өгөхгүй байгаа янзтай хий л нухчин тунтганана. Одоо амтыг нь бүрэн авах шиг боллоо гэхтэйгээ зэрэг Мятав хүүдийтэй мэхээрийг угз татсан гэнэ. Баавгай амттай хэр нь «амьтай» хоол гэж байдаг байж дээ гэсэн янзтай цочсоноо хүүдий рүү ам хамраа шилэмдсээр очиж бас л долоолов. Удвал хүүдийг нь хүү татчихаад аль ч үгүй болно. Баавгайд тухлах чөлөө өгөхгүй юм шүү гэж бодон сураасаа угз татав. Бас л хойноос нь айсуй.

Мятав ч гэрийн зүг ергүүлсээр, баавгай ч хүүдийтэй мэхээрийн хойноос шогшсоор. Ёстой барахгүй цадахгүй хоол гэдэгтэйгээ тэр баавгай учирчээ. Ойртож ирээд долоотол гэнэт годхийн алга болно. Амттайг нь бодвол идэж барж салахаас нааш санаа амрахгүй гэсэн янзтай хүүдийтэй юмтай өнөөх баавгай хөөцөлдсөөр.

Нар хүүшлэхийн алдад баавгай, хүүдийтэй мэхээр, Мятав гурав гэрийнхээ урд модтой толгойд хүрч иржээ.

Хэдэн хурганд жаахан юм үлдвэл харамлаад ч яах вэ идвэл идэг, гэрийнхээ хаяанд ч ирлээ гэж бодоод бууж, буугаа зэхлээ. Баавгай, баригдаж өгөхгүй зовоосон хоол тогтсонд санаа нь амарсан бололтой, өнөөх хүүдийг хүү татан амаа олохгүй үмхэлж эхэллээ. Өрөвдмөөр гэнэн ч амьтан юм уу даа. Алж хядахын дон туссан биш, гэм тариагүй амьтан шүү дээ энэ чинь. Буудалгүй орхичихдог ч юм бил үү гэж бодож байтал мэхээр нь барагдсан ч юм уу, хорхой нь дарагдаж ухаан ороод хажууханд нь хүн байгааг гэнэт олж үзэж зэвүүцсэн ч юм уу, муухай архираад дайрах гэжээ. Тэгмэгц Мятавын санаа шулуудан түүнийг буудан унагав. Хаа байсан алсын хяраас хаяандаа тийм том ан дагуулан авчирч эд бад хийснийг хүмүүс нүдээрээ үзэж байж арай гэж үнэмшсэн билээ.

## ХӨШҮҮРГИЙН ЭРДЭМ

Ойрд үзэгдээгүй хэдэн морио харах, бас ч малгайнхаа үсийг сэргээе үү гэж Мятав Батхаан ууланд гарсан юмсанжээ. Бараг цатгалан оготно шургаж багтамгүй шигүү ойд модны мөчиртэй ноцолдсоор яваад нэгэн хэсэг чөлөөнд гарч иртэл хүний давчидсан муухай хашхирах дуу, модны мөчир шажигнан хугарах чимээ гарав. Эргэн тойрон юу ч алга. Хүний хашхирах дуу ойртсоор. Хариу чимээ өгчээ.

Модны мөчир гишүү тас нясхийж байснаа дээрээс нэг хүн ум хумгүй харайж яваа харагдлаа.

— Амь авар! Зэрлэг гахай! гэж өнөөх хүн хашхирсаар наашаа байдаг чинээгээрээ харайж байв. Ойн хэсэг чөлөөний цаад шигүү мод ярагдан зугтсан хүний замаар нэг том гахай гарч ирэв ээ!

— Хэрэг бишидлээ яадаг билээ. Гар хоосон хүн зэрлэг араатны өөдөөс ямар хариу хийдэг хэрэг вэ? Харсаар байж эрдэнэт хүнийг зэрлэг араатны аманд өгч яаж болох вэ гэж Мятав гайхшаа баран бантаж зогссоноо, эргэн тойрноо харав. Гэтэл нэлээд урт барагцаалбал дөрөв таван алд хэрийн овоо бядтай сургааг хэвтэж байлаа. Бас л гэнэт нэг

санаа тархинд нь харван орж иржээ. Түүнд учиргүй олзуурхан «дэр, дэр» гэж амандаа шивнэн ийш тийшээ харав. Хажууханд минь бүдүүн гэгчийн салаа мод харагдлаа. Модны ац овоо өндөр ханын эрсийн дайтай байсан санагдах юм.

Хүн гахай хоёр модонд тээглэхгүй болохоор аль аль нь байдгаараа хурдалж байгаа бололтой. Ус уух хувьтай хүн юм даа. Хүний үр ялгаа юу байх вэ хөөрхий, хийморьтой л явна шүү хэмээн баярлаж:

— Наашаа чиглээд гүй! харайгаад бай! гэж хашхирлаа. Өнөөх хүн ч амь тэмцэн харайсаар айлын дайтай ойрхон ирлээ. Мятав.

— Битгий сандар! Энэ сургаагийн үзүүр дээгүүр харайгаад гар! Хол битгий явчхаарай гэж хашхирлаа.

Өнөөх хүн ч амь авах эцсийн арга энэ гэсэн шиг улаан гүйхээрээ ирж заасан ёсоор нь сургаагийн үзүүр дээгүүр эрчээрээ харайлаа. Том бодон ч аманд орсон олзыг алдахгүй гэсэн шиг хар хурдаараа айсуу.

Мятав биеэ харагдуулахгүйг хичээн модонд таширлан зогсоод, сургаагийн их талын үзүүрээс барин анаж байлаа.

Бодонгийн урд хоёр хөл сургаагийн нөгөө үзүүр дээгүүр гарч ирэнгүүт л барьж байсан үзүүрээ байдаг чадлаараа огцомхон нь аргагүй, газарт шигдтэл дарчихсан чинь хүчтэй хөшилтөд өртөгдсөн өнөөх бодон эргэлдсээр дээшээ хөөрч гарчээ. Ончийг нь тааруулж хөшсөнийх юм байх даа, хөөрөөд л байж. Нэг харсан чинь бүр дээр гарчихсан бараг л хомоол шиг жижигхэн хар юм харагдаж байсан гэнэ.

Удаж удаж бодон доошилж, яг л харвасан сум шиг юм бууж ирэхэд газар лүг хийн доргих шиг боллоо.

Тэр том биетэй амьтан толгойгоороо газар шааж унасан бололтой, толгой нь бараг чээжиндээ орчихсон байжээ.

Ингэж тэр хоёр хангай дэлхийн хайрласан хишгийг санамсаргүй хүртэж, том ангаар ганзагаа мялаажээ. Эр хүн гэдэг чинь эрээрээ, сүрээрээ, ухаанаараа хээрийн догшин хэрцгий араатны сүр сүлдийг зайлуулж явах учиртай юм гэж Мятав ярих дуртай.

## ДАХИАД Л ТОМИЛОЛТ АВАХААС ДАА

Миний томилолтын үр дүн энэ. Эрэл маань урагштай бүтэмжтэй байгаад олзуурхсаар нийслэл хотдоо буцаж ирлээ.

Эрдэнэ гуайн зааснаар баримжаалж, адтай Мятавынхыг сураглан явсаар тав дахь хоногийн өглөөгүүр орон сууцын шинэ хорооллын тохилог байрны нэгэн хаалгыг тогшив.

Хананд янхигардуу чацархаг бие, унжуудуу хамар, урт эрүүтэй, дөлгөөн сайхан нүд, хэдэн гүн үрчлээ суусан өргөн саруул магнай бүхий ухаалаг байрын нүдэнд дулаахан сайхан өвгөний зургийг хүндтэй байрлуулжээ.

Тэр гарцаагүй адтай Мятав мөн! Би Мятав гуайг нэг л ер бусын хүн байдаг болов уу гэж төсөөлөн бодож явсан юм. Гэтэл санаснаас огт өөр, хүн хүнээс онцгойрч ялгарах юм даанч үгүй, ёстой л хамгийн эгэл жирийн хүн байлаа.

Хаалга тайлж, тохилог аятай гэртээ урин оруулсан төлөв сайхан эмэгтэй ч яг аавыгаа дуурайж төржээ.

- Танай аав чинь Мятав гуай бил үү?
- Тийм ээ
- Аа ашгүй, би уулзах гэж ирсэн юмсан.
- Аав өнөө өглөө дүүгийн д очихоор Өвөрхангай аймаг руу онгоцоор явчихсан шүү дээ гэсэн уриалагхан намдуун дуу намайг балмагдуулав.

Дахиад л томилолт авахаас даа

*1980 он*

## 1983 оны хэвлэлийн Хэвлэн нийтлэлийн мэдээлэл :

Ш. Цэнд-Аюуш

Адтай Мягав  
(тууж)

Хоёрдох удаагийн хэвлэл

Редактор Ц. Мөнх

БНМАУ  
АРДЫН БОЛОВСРОЛЫН ЯАМНЫ ХЭВЛЭЛ  
УЛААНБААТАР 1983 ОН

Хэвлэлийн редактор Ө. Баасанжав  
Зургийг Д. Батсуурь  
Уран сайхны редактор П. Төмөрпүрэв  
Техник редактор Г. Шаалай  
Хянагч Ж. Даваадорж, Д. Самбуу-Ёндон  
Б—88695  
Х г. № 100/83  
За № 68

Өрөлтөд 1983 оны 6 дугаар сард,  
хэвлэлд 1983 оны 10 дугаар сард шилжүүлж  
20 000 ширхэг хэвлэв.  
Цаасны хэмжээ 84X108/32  
Х.х 1 Х.н.х 1,68 Т.х 1,0  
Үнэ 60 мө.

Армийн СХ-ийн хэвлэх үйлдвэр  
Улаанбаатар Партизаны гудамж 2